

Шагдарсүрэнгийн ЦЭРЭНДОО (Монголын сэтгүүлчдийн эвлэлийн нэрэмжит шагналт хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан)

ЧҮЛТЭМ ДАРГАД ЧАДАХГҮЙ АЖИЛ БАЙГААГҮЙ

Монгол улсын зүүн өмнө хязгаар түгшүүртэй болсон 1938 онд Төв аймгийн ардууд 67,4 мянган төгрөг хуримтлуулж Тамсагбулагийн 17-р хороог шефлэн авч ВД танк 1, истербител онгоц 1-ийг өгөхөөр 22401 төгрөгийг шилжүүллээ. Армийн дайчдад 473 захидал илгээж, цэргийн ар гэр 663 өрхийг МАА-н албан татвараас чөлөөлж, 558 өрхийг татвараас хөнгөлж, 87 өрхөд мөнгөн тусламж үзүүлжээ гэж “Эх орон-52” араажав зарлаж байх сацуу Гээзгийн хөөврийн Даравгайд хаваржиж буй боржигин Цэндийн Дугарсүрэнгийн баруун хатавчинд нэгэн эх амаржиж дуусуут, гэрт орцгоосон хүмүүс тулгын гал тойрч тухлаад:

-Аштай юу даа, энэ цөв цагт хүү төрдөг чинь сайн хэрэг. Эх орноо хамгаална шүү дээ гэж цаг төрийн үгээр ам нээж, цэргийн хүүгийн буянаар албан тавараас чөлөөлөгдсөнөө хөөр болгож сууцгаалаа.

Тэр хүү цэрэг цэрэгтээ жанжин болчих санаатай Сүхбаатарын нэрэмжит цэргийн сургуульд “онц” төгссөнөөрөө түрээ барин хуваарь аваад харив. Гурван сартайгаас нь үрчлэн тэжээсэн эцэг Жамсранжав, эх Норжмаа нар уулга дуун алдаж “Ээ гэгээн минь юун цэрэг цуух” бага сургууль төгслөө гэдэг чинь эрдмийн шим хүртлээ гэсэн үг. Аав нь сумын даргатай уулзна. Ахлах ухуулагч хийх хүн эрж явна гэнэлэй. Миний хүү бичиг номтой болчихсон юм чинь чадахаа л чадна гэснээр заханд нь улаан цэнхэр дээр алтан өлзий утас хатгасан петлиз, ханцуйд нь алтан соёмбо бүхий сумны зэв хэлбэрийн ялгах тэмдэгтэй жанжин хүний форм, гоё малгай үлгэр болон үлджүхүй.

Ингээд Чүлтэм хүү багийнхаа айлуудаар явж цэргийн захиа дуудан өгч, охидын гуйлтаар цэргийн ахад “Ам цагаан цаасаар элч болгож, алтан номын үсгээр бие хийсэн” захидал бичиж, аймаг улсын ажлыг араажавтай уралдан ярьж ухуулгын ажлаа, 12 мөнгөний дэвтэр дээр “А”-гаас “Я” хүртэл хуулуулан үсэг зааж, хятад сампинд тоо бодуулж бичиг үсгийн багшийн ажлаа амжуулж, тэр бүхнийг хийсний төлөө сард 17 төгрөгний цалин хүртэж нэг хэсэг үзэв.

Ухуулагчийн аманд “нэгдэл” гэдэг үг нэгэн хэсэг зай эзлэж, хүмүүст олон ярьсан зүйл нь өөрт нь итгэл үнэмшил болоод 17-уул санал нэгдээд “Хөгжлийн зам” нэртэй нэгдлийг Өндөрширээт сумандаа байгуулж Чүлтэм хүү нярав+нягтлан болоод сууж гүйсэн нь 1956 он.

“Нэгдэлжих хөдөлгөөн яллаа” гэж нам, засаг зарлахад 21 настай Чүлтэмийг сумын залуучууд ХЗЭ-ийн үүрийн нарийн бичгийн даргаараа сонгочихов. Ухуулагч хийж улстай “нүүр хагарч” ойлголцохуйн аргад орсон нь баг сумынхаа бар морь жилтнүүдтэй ажиллахад бас ч эвтэй, бичиг үсгийн багш явсны хэрэг юу билээ, мэддэгийгээ нөхөддөө зааж, жараад оны “соёлын довтолгоон”, “социалист уралдаан”, цалингүй ажил субботник, лекц дугуйлан, “ленинч шүүлэг”-ийг давжээ. Цэргийн дарга болох хүсэл нь Чүлтэмд ингэж залуучуудын дарга гэдэг албаар хэрэгжив.

“Мэдэхгүй, чадахгүй хоёр бол залуучуудын дайсан

Мэдлэг, хүч хоёр бол залуучуудын нөхөр” Ц.Гайтав. ийм л номлолтой тэр цагийн идэрчүүд хөдсөн дээлтэй хөдөөгийн цэрэг л гэсэн үг. “Тэг” гэсэн тушаалд “За” гэсэн андгаартай гарч өгнө. Улсын төлөвлөгөө, уралдааны үүрэг биелүүлэх гээд хөсрийгөөс зэс гууль, хөнгөн цагаан, харганы ноос түүх, хад чулуу кублэх, адуу дэллэх, ятуу агнах,

хангал эмнэг сургах, хашаа саравч барих, хадлан, тариа, ан гөрөө, яс нэрж тос тунгааж, түймэр унтрааж, чухамдаа нэр нэрийн ажлаас нэгийг ч үлдээлгүй чадаж, өвлийн хүйтэн, хаврын хавсарга, ган халуун нар, гал усан бэрхэд цөхөрч няцахыг мэдэхгүй гүгийтэл зүтгэж “социалист Монгол”-ыг бүтээлцжээ. “Соёлын хувьсгал” гээчийг хийлцэж улаан булан ухуулга, таниулга, хурал цуглаан, үдэшлэг уулзалт, нийтийн бүжиг, нийгмийн идэвх оргилуулж Чүлтэм дарга Өндөрширээт, Баянзүрх, Тариат сумын ХЗЭ-ийн үүрийн даргыг 1967 оны 7 сар хүртэл, тэгээд ч болоогүй ээ, Баянцогт, Заамар, Эрдэнэсант сумын Эвлэлийн байгууллагад 1990 он, тавин нас давталаа тэргүүлэгчийн үүргийг хүлээж залуу настныг залсаар заасаар ирсэн нь мэдлэг арвин, сэтгэл идрийнх буй за.

-Яажшуухан ажиллаж байв даа гэсэн асуултанд минь

-Битүүний шөнө малчдын сайн өдрийн концерт бэлтгэж ид завгүй бужигнаж байхад эхнэр маань амаржсан байлаа. Өндөрширээт суманд 1964 оны цагаан сар даа.

Туулын гол үерлэж усны аюулд Тариат сумын сүүн тасгийн айлууд автаад эвлэлийн үүрийн бүх гишүүдээ аваад би тэднийг нүүлгэж өдөржин усан дунд аг маггүй ажилласаар орой харихад эхнэр маань гуравдахь хүүгээ төрүүлчихсэн байлаа. 1966 он доо.

Би 1957 онд эмэгтэй Ч.Халтартай гэр бүл болж гурван хүү, хоёр охин төрүүлж өсгөсөн хүн дээ. Одоо энх тунх амьдарцгааж байна. Би одоо 76-тай даа.

Төв аймаг байгуулагдсаны 40 жилийн ой угтаж аймгийн төвд 5000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнг субботникоор барихад би арван залуутайгаа “гавшгайч бригад” болж ирээд барилгачин болж явлаа. Алийг тоочиж барахав дээ.

Дарга хүн хоцрох эрхгүй тэр нийгэмд Чүлтэм дарга өөрийгөө өөд татаж ажлынхаа заваар номыг нь үзэж шалгалтыг нь өгсөөр долдугаар ангийн гэрчилгээ сумын сургуулиас гарджээ.

Хүнээс хүзүү дутахгүй гэж мэрийсээр яваад авдаг шалгалтыг нь өгөөд Д.Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуульд элсээд авчихав. Жанжинаар овоглосон цэргийн сургуульд эс ч монголдоо тод манлай тэр сургуулиас “эдийн засагч” “зохион байгуулагч” мэргэжлийн 1001 номерийн диплом гардсан байна.

-Аймгийн намын хорооны даалгавраар Баянцогт, Заамар, Эрдэнэсант сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч даргаар ажиллаж явлаа. Баянцогт сумын АДХГЗ-ны орлогч даргаар ажиллах томилолтоо авахад аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ц.Жамсран гуай: “МХЗЭ-ийн тэргүүний ажилтан та тэр санаачилга зүтгэлээ улам сайжруулан үр бүтээлтэй ажиллаж орон нутгийн төр захиргааны тэргүүний ажилтан болтлоо идэвх санаачилга гаргаарай” гэж захиж билээ.

Эрдэнэсант сумын гүйцэтгэх захиргааны орлогч даргаар ажиллаж явахад улс нэг том шинэ туршилт хийсэн нь миний хариуцсан ажилд холбогдсон юм. Тэр юу вэ гэхлээр суманд бие даасан төсөв өгөөд түүнийг захиран зарцуулах эрх олгож болох нь уу, үгүй юу гэдгийг туршиж үзэх явдал байв. Энэ бол ганц Эрдэнэсант сум, миний алба ч төдийгүй Монголын хоёр зуун ерээд сумын хувь заяатай холбогдолтой хариуцлагатай ажил байв. Би санхүүгийн тасаг байгуулж нэг нягтлан бодогч аваад нэг жил заавараар нь ажиллаад шалгууллаа. Сангийн яамны хүмүүс ирж тооцоод бодоод болох юм байна гэсэн дүгнэлт өгч бүх сум тэр мэтчилэн ажиллах болж байлаа. Энэ бол сумдын хөгжилд нэг алхам ахисан зүйл байсан.

Чүлтэм дарга сэдэж сэтгэж шинэд тэмүүлж, намын гишүүний манлайлж түүчээлэх яс чанарыг уураг тархи, улаан цусандаа шингээж өссөн болохоор ард олон ч андаж эндэхгүй, ачаа даалгавар нэмээд л өгнө. Сумын хуралд депутат, үйлдвэрчний хорооны

дарга, эвлэлийн хорооны тэргүүлэгч, МАА-н бригадын намын үүрийн дарга, за тэгээд суманд ямар л олон нийтийн байгууллага, цалингүйгээр идэвхээрээ гүйцэтгэх ажил байна, тэр бүхэнд сонгуультай. Алд биеийг арав хорь хуваагаад л ажиллаж гарна. “Нэг нь нийтийн төлөө” нийгэмд тийм хүмүүс ажиллаж явсныг өнөөгийн залуус нүдээ бөлтийлгэж гайхна шүү дээ.

Сумын бүртгэлийн ажилтнууд-нягтлан бодогчид, эдийн засагчид, нярав нарыг хамруулаад социалист өмчийг хамгаалах, бүртгэл тооцоог нарийвчлах, хөдөлмөрийн бүтээмж, үр ашиг, фонд өгөмжийг нэмэгдүүлэх, өөрийн өртгийг хямдруулах, тэгээд өөрсдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх жишгээр олон үүрэг авсан. Социалист хөдөлмөрийн төлөө бригад байгуулж ажиллаад мандатыг нь авч мандаж явсан цаг 1972 он. Чүлтэм дарга ийм л хүн.

Тэр үед хэн сайн ажиллаж амжилтаараа манлайлнам түүнийг хийдэг сонгууль болон томиллотот ажлынх нь чиглэлээр улсын хэмжээний хурал зөвлөлгөөнүүдэд төлөөлөгчөөр сонгож оролцуулан туршлагыг нь яриулж, үгийг нь хэлүүлж ажил амжилт ахиулах санаа оноогоор нь нам, засаг зорилго зорилтоо гэрэлтүүлдэг байсан билээ. Чүлтэм дарга МХЗЭ-ийн ХИҮ, ХҮ Их хурлын төлөөлөгч, МҮЭ-ийн идэвхтэний улсын II зөвлөлгөөний төлөөлөгч, Бүртгэл статистикийн ажилтны улсын II зөвлөлгөөний төлөөлөгч, Монголын Байгаль хамгаалал, Анчдын нийгэмлэгийн ИҮ, Ү Их хурлын төлөөлөгч, Төв аймгийн намын XXII бага хурлын төлөөлөгч, аймгийн Ардын хурлын депутат, сумын депутатаар 1962 оноос 1992 онд шинэ Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан нутгийн өөрөө удирдах байгууллага-сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар сонгогдох хүртлээ ажилласан. Тэр бүхний цаана дандаа бодитой ажил бүтээл байсныг онцлон тэмдэглэвэл зохино.

-Төр цагийн эргэлт гэдэг сонин юм шүү. Би Өндөрширээт суманд нэгдэл байгуулж явсан бол нэгдэл тарахыг үзэж, Эрдэнэсант сумын “Саруул амьдрал” нэгдлийг хувьчлан хувааж гурван компани болгоход нь “Сайхан” компани байгуулалцаж, нягтлан бодогчоор нь ажиллаж явлаа. Бүхий л юмын үүсгэлд бүрлэхийн шалтгаан нь байдаг гэж үнэн шүү. Соц нийгэм тэр, одоо энэ ардчилсан нийгэм энэ. Олны ам ямар байна вэ?

-Та “Хөгжил” нэгдлийн нягтлан, “Сайхан” компаний нягтлан, сумын гүйцэтгэх захиргааны орлогч дарга гэдэг чинь тоо тооцоо бүртгэл гэсэн үг биз дээ.

-Тийм шүү. Миний ахмад үед, тэгээд бид ч гэсэн дээ “төдөн цаас мөнгөн нь чагаа” гээд уянгалуулан хятад сампингийн эрхийг харах ч үгүй хурууны өндөгнийхөө мэдрэмжээр шажигнуулж явснаа цифрийг нь гүйлгэж тааруулаад даллан эргүүлдэг тооны машинтай нэг хэсэг үзэж, тэгээд хичнээн ч техникийн дэвшлийн үе өнгөрснийг бүү мэд, цахилгаанаар, нараар ажилладаг электрон тооцоолууртай залгав шүү. Одоо компьютер. Ингээд бодоход он уджээ. Нээрээ ч эхнэр маань 74-тэй, хүү, охид, ач зээ дөч шахаад өнөр өтгөн болжээ би.

Чүлтэм даргад цэргийн шугам жагсаал шиг тоо чухал, тоо болгон утгатай, бодитой амьдрал тольдож иржээ. Түүний тоон толинд Баянцогт, Заамар, Эрдэнэсант сумдын жар, дал, ная, ерээд оны амьдрал буцалж байлаа. Би арай хийсвэр хэлж байх шиг байна. **Баянцогт** сум 1933 онд явагдсан хүн, малын тооллогоор 7 багт 701 өрх, бүх хүн 3200, үүнээс эрэгтэй 1000, лам 200, эмэгтэй 1100, бүх мал 68200, үүнээс тэмээ 200, адуу 7800, үхэр 11000, хонь 47400, ямаа 4800 тоолуулжээ. Тооноос түүх гэрэлтэхийн жишээ энэ. **Эрдэнэсант** сум 1966 онд авто машин 22-той, 1970 онд 36, 1980 онд 63-тай, ердийн хөсгөөр тээсэн ачаа 1971 онд 400 тн, 1975 онд 900 тн, 1980 онд 100 тн. Радио цэг 1962 онд 30, 1980

онд 60, хүлээн авагч 1969 онд 361, 1987 онд 840, телевизор 1986 онд 50, 1988 онд 70, телефон цэг 1971 онд 30, 1980 онд 50 эдгээр тоо өнөөгийн цагт инээдэмтэй ч амьдрал тийм байсныг үгүйсгэх аргагүй.

Төв аймагт анх түрүү 1968 онд ЗХУ-ын тусламжаар Заамар сумын “Заамар” нэгдэлд контор, 2 айлын 2 өрөөтэй сууц 22, 3 өрөөтэй сууц 6, 200 хүний суудалтай бүх төхөөрөмж бүхий клуб, 320 хүүхдийн хичээлийн байрны 2 давхар барилга, 120 хүүхдийн дотуур байр төхөөрөмжийн хамт, бүрэн тоноглогсон гуанз, хоногт 1 тонн талх гаргах талхны газар, 30 тракторын засварын газар, сэлбэг материалын агуулах, 100 тн ногооны зоорь, мал эмнэлгийн амбулатор, 330 кВт-ын чадалтай цахилгаан станц, 15 машины зогсоол, завсарын цех бүхий авто гарааш, ус өргөх цамхаг, 250 шоо метр ус хадгалах усан сан, насос станц, 6 тогоотой уурын зуух, тариа бригадын төвд контор, 3 өрөөтэй 2 айлын сууц, 2 өрөөтэй 2 айлын 10 сууц, 25 ортой ясль, цэцэрлэг, халуун ус, дэлгүүр, 50 хүний суудалтай улаан булан, номын сан, засварын цех, 500-800 тн будаа хадгалах үрийн агуулах хоёр, 24 квт-ын АСД-2 маркийн цахилгаан станц 2, үрийн механикжсан агуулах, тэжээл няцлах тээрмийн барилга тоног төхөөрөмжийн хамт, цахилгаан болон уур усны шугам сүлжээ, талбай, зам, зүлэгжүүлэлтийг хийж, МАА-д 600 хонины хашаа 44, саалийн үнээний битүү байр 28, тугаллах үнээний 14 байр, өсвөр үхрийн 28 байр, 1200 богийн хашаа 24-ийг барьж моторт худаг 3, бетон цагригтай насостой худаг 71-ийг гаргаж өгчээ. Тоо, тооцоо, бүртгэлийн ач холбогдол ийм юм. Энэ бүхнийг эшлэхийн учир Чүлтэм дарга улс эх орондоо хөдөлмөрлөсөн жилүүдийн үнэ цэнийн нэгээхэн хэсгийг тодруулахын тулд болой. Олон ч товхимол, сонин хэвлэлд туршлага нь нийтлэгдсэн байна. Сайн ажилласан болохоор тэгэхээс ч биш яахав.

Төр засаг Чүлтэмийн хөдөлмөр зүтгэлийг үнэлж МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв зөвлөлийн “Хүндэт жуух бичиг”, Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Ардын хувьсгалын 50, 60, 70, 80, 90 жилийн ойн медадиуд, IY, Y таван жилийн гавшгайч, Ардын хянан шалгах хорооны тэргүүний ажилтан цол тэмдэг, Засгийн газрын хүндэт жуухаас эхлээд өдий төдий баярын бичиг гэрчилгээ олгожээ. Дээр нь улс орны томчуулын урам хайрласан үг бас л шагнал юм. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, монгол төрийн хаан Ж.Самбуу, МЗХЭ-ийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ч.Пүрэвжав, хоёрдугаар нарийн бичгийн дарга, нутгийн эрхэм Б.Барамсай, Монголын эмэгтэйчүүдийн хорооны дарга, Зохиолчдын хорооны дарга С.Удвал гээд л томчууд түүнд зөврүү сайхан үг хэлж ажлыг нь дүгнэжээ. Жишээ нь Ардын Их хурлын депутат Лувсанравдан Тариат сумын хөдөлмөрчдийн хурал дээр “Монголын олон арван тэргүүний ХЗЭ-ийн байгууллагын нэг, танай сумын ХЗЭ-ийн үүр, МХЗЭ-ийн тэргүүний ажилтан Чүлтэмд МАХН-ын бэлтгэл хүч, дайчин туслагчийнхаа хүндтэй үүргийг сайн биелүүлж байгаад МАХН-ын Төв хороо болон хувиасаа баяр хүргэе” гэсэн үг сэтгэлд нь хоногшин үлджээ. Тэр үед дайчин манлай МАХН-ын Төв Хорооны өмнөөс баяр хүргүүлнэ гэдэг асар хүндтэй шагнал байлаа.

Чүлтэм дарга одоо Зуунмод сумын IY багт охиныхоо гурван хүү, эхнэрийнхээ хамт таван ханатай гэртээ тавтай сайхан аж төрж сууна.